

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН БАТАЛСАН 29/01 ТООТ УДИРДАМЖИЙН ДАГУУ
АЙМГИЙН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨД ДОТООД АУДИТ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭЛЭЭ.**

1. Нийтлэг үндэслэл

Санхүүгийн хяналт, Аудитын албаны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу орон нутгийн төсвийн төлөвлөлтийн үйл ажиллагаанд Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, 14.2.10-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэсэн заалтыг үндэслэн дотоод аудит хийж дүгнэлт өгөх, илэрсэн асуудалд чиглэсэн зөвлөгөө өгөх, цаашид үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд оршино..

2. Аудитын зорилго:

Өвөрхангай аймгийн орон нутгийн төсвийн төлөвлөлт түүний үр нөлөөтэй байдлыг үнэлж дүгнэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, тус төлөвлөлтийн үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө өгөх замаар орон нутгийн төлөвлөлтийн үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилготой.

3. Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт

Дотоод аудитад Аймгийн 2020 оны орон нутгийн төсвийн төлөвлөлтөд дотоод аудитыг хийх зорилго тавьсан тул аймгаас улсын төсөвт оруулдаг орлогын төлөвлөлт болон тусгай шилжүүлгийн байгууллагуудын улсаас олгодог санхүүжилт, түүний төлөвлөлт, орон нутгийн төсвийн гүйцэтгэлийг энэ удаад хамруулахгүй.

ИЛЭРСЭН АСУУДАЛ

1. Зарим сумдууд төсвийн төслөө цаасаар ирүүлээгүй
2. Сумдын нэг ажилтны жилд хэрэглэх бичиг хэргийн зардлыг байгууллага бүр ялгаатай тогтоодог
3. Шатахууны зардлын тооцоолол газар нутгийн хэмжээ, байршил зэрэгтэй уялдаагүй
4. Албан томилолтын зардлыг байгууллагууд харьцангуй зөрүүтэй тооцдог
5. Төрийн байгууллагын халаалтын талбайг хэмжсэн нэгдсэн судалгаа байхгүй
6. Эрчим хүчний бодлого зохицуулалтын газраас баталсан үнэ тарифыг мөрддөггүй
7. Батлагдсан орон тооноос хэтрүүлэн ажилладаг
8. Аж ахуйн нэгжүүдийн нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан, цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татварын тайлангийн цалингийн сан зөрүүтэй
9. Ус рашааны төлбөрийн орлогын төлөвлөгөөг оновчтой хийдэггүй
10. Түгээмэл тархацтай ашигт малтмалын орлогыг төлөвлөгөөнд бүрэн тусгадаггүй
11. Галт зэвсгийн албан татварыг бодит байдлаас их хэмжээгээр төлөвлөсөн
12. Нохойны хураамжийн төлөвлөлтийг үнэн бодитой хийж чадаагүй
13. АТӨЯХэрэгслийн татварыг бүрэн төлөвлөдөггүй
14. Замын сангийн хураамжийг дутуу ногдуулсан
15. Газрын төлбөрийг дутуу ногдуулсан

ЗӨВЛӨМЖ

1. Төсвийн төслийг гарын үсэг тамгаар баталгаажуулсан байдлаар хүлээн авч байх
2. Ингэж ирүүлээгүй байгууллагуудад хүлээлгэх хариуцлагыг Төсвийн тухай хуульд нийцүүлэн журамлах
3. Зардал тус бүрийг төсөвлөх чиглэл, аргачлал, норм, норматив, нэг хэв загвар бүхий маягыг Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2019 оны 445 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал”-д нийцүүлэн гарган баталж мөрдүүлэх
4. Төсвийг нэгтгэхдээ төсвийн төсөл хийсэн тооцоолол, үндэслэлийг нэг бүрчлэн шалгаж байх
5. Суурь зардал болон төсөвт зардлуудын уялдааг сайжруулах суурь зардлаас хэт давсан төлөвлөлт хийхгүй байх
6. Төсвийн төсөлд тусгасан зардлын дүнгээс хэтрүүлж төсвийг баталдаг үүний улмаас дараа оны суурь зарлага механикаар өсдөг байдлыг таслан зогсоох
7. Нэг төрлийн зардлыг төлөвлөхдөө нэг сумын байгууллагууд хэт ялгаатай үнэ хэрэглэдэг байдлыг таслан зогсоох
8. Төсвийн төсөл хийхэд шаардлагатай мэргэжлийн байгууллагаар баталгаажсан нэгдсэн суурь судалгаатай болж жил бүр баяжилт хийж байх
Үүнд: халаалтын талбайн хэмжээ, бичгийн цаас хэрэглэх албан хаагч нарын тоо, бичгийн цаас, шатахууны үнэ гэх мэт
9. Дулааны эрчим хүчний үнэ тарифыг Эрчим хүчний бодлого зохицуулалтын зөвлөлөөр шинэчлэн тогтоолгуулах. Ингэхдээ бодит тооцоо судалгаан дээр үндэслэх
10. Тогтоосон үнэ тарифыг 1м3 халаалтын талбайн үнийг ялгаатай байдлаар хэрэглэхгүй, хуулийн хүрээнд Эрчим хүчний бодлого зохицуулалтын зөвлөлөөс тогтоосон үнийг нэгдсэн журмаар мөрдөх
11. Арвайхээр, Хархорин сумдын багийн зохион байгуулагч, Нарийнтээл сумын Баянтээг багийн багийн зохион байгуулагч, нийгмийн ажилтан, Уянга, Хужирт, Хайрхандулаан сумдын хөдөлмөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн нийт 18 албан хаагчийн үйл ажиллагаанд чиг үүргийн шинжилгээ, ажлын байрны зураг авалт хийж ажлын ачааллыг тодорхойлж, илэрсэн асуудлын хүрээнд эдгээр орон тоо нь байх шаардлагатай эсэх талаар шийдвэр гаргах
12. Гэр бүл хүний хөгжлийн төвийг аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хэлбэрт шилжүүлэх
13. Аймгийн Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/838 тоот захирамжаар батлагдсан орон тооноос Арвайхээр сумын ЗДТГ-ын хотын захирагчийн албаны 4, Бүрд, Өлзийт сумуудад тус бүр жолоочийн 1 орон тоо, Уянга суманд сахиулын 1 орон тоо, бизнес хөгжлийн төвийг халаадаг уурын зуухны машинистын 3 орон тоо, Есөнзүйл суманд 1 багийн сахиул нийт 11 орон тоонд ажлын байрны шинжилгээ хийж цаашид үргэлжлүүлэн ажиллуулах эсэх талаар шийдвэрлэх. Бүрд, Өлзийт сумуудад тус бүр

- жолоочийн 1 орон тоо, Есөнзүйл суманд 1 багийн сахиулын орон тоо илүү ажиллаж байгааг шаардлагагүй гэж үзэж байгаа тул үүнийг таслан зогсоох
14. Сумдыг ЗДТГ, багийн төвийн байруудад ажиллаж байгаа үйлчлэгч нарын орон тоог хариуцаж байгаа ажлын байрны талбайн хэмжээг Засгийн газрын 2019 оны 445 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал”-д зааснаар тооцон үзэж шаардлагатай орон тоог үнэн бодитой тогтоох. Мөн Баян-Өндөр, Баянгол, Зүүнбаян-Улаан сумдын ЗДТГ-ын байрны хэмжээ нормоос бага байгаа тул энд ажиллаж байгаа үйлчлэгчийн орон тоог өөр байгууллагын үйлчлэгчийн орон тоотой хамтатгах, эсвэл өөр ажил үүрийг хавсруулан хийлгэх боломжийг судалж шийдвэрлэх
 15. Жил бүр төсвийн төслийг Сангийн яаманд хянуулахдаа хасагдсан орон тоо, түүний шалтгааныг албан тушаал бүрээр тэмдэглэн авч эдгээрийг цаашид хүлээн зөвшөөрүүлэх талаар судалгаа, тооцоолол хийж байх
 16. Аймгийн НДХэлтэс, Татварын хэлтэстэй хамтран орлого нэмэгдүүлэх боломжтой ААНэгжүүдийг судлан судалгаа тооцоог хийх. Татвар төлөх сонирхолгүй байгаа аж ахуйн нэгжийг идэвхжүүлэх, хөшүүргийн арга хэрэгсэл хэрэгжүүлэх
 17. Аймгийн хэмжээнд ус, рашаан, түгээмэл тархацтай ашигт малтмалыг үйл ажиллагаандаа ашигладаг иргэн, ААНэгжийн үнэн зөв судалгаатай болж жил бүр баяжилт хийж байх
 18. Судалгааны дагуу бүх аж ахуй, нэгж, иргэнийг ус ашиглах дүгнэлттэй болгох, дүгнэлт, зөвшөөрөл, гэрээгүйгээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсоох хүртэл арга хэмжээг авч ажиллах
 19. Судалгааны дагуу БОАЖЯамны газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого зохицуулалтын газар, БОАЖГ, Онги-Таац голын сав газрын захиргаа, Чулуут голын сав газрын захиргаанаас гарсан дүгнэлтүүдийг үндэслэн орох орлогыг сум орон нутгийн төлөвлөгөөнд бүрэн тусгаж байх
 20. Дараа жилд ус ашиглах байгууллага, аж ахуйн нэгж, иргэний судалгаа, мэдээг тухайн оны 05 дугаар сараас хэтрүүлэхгүй гаргаж үүний дагуу ус ашиглах дүгнэлтийг төсвийн төсөл хийгдэхээс өмнө гаргуулах талаар шаардлага тавьж хэрэгжүүлж ажиллах
 21. Усны төлбөр хэт бага байгааг нэмэгдүүлэх талаар Байгаль орчны яаманд санал хүргүүлэх
 22. Аймгийн хэмжээнд галт зэвсэг эзэмшигч иргэн, ААНэгж, байгууллагын үнэн зөв судалгаатай болох ажлыг зохион байгуулах. Бууны тооллогыг нүд үзэж тоолох гэх мэт
 23. Тухайн онд баригдаж байгаа барилга байгууламжид ашигласан элс, хайрганд ногдох орлогыг орон нутгийн төсөвт оруулахаар төлөвлөлтийг хийх
 24. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл авахад тавих шаардлагад заасан талбайн хэмжээг орон нутгийн зах зээл, хэрэгцээнд үндэслэн багасгаж тооцдог байхаар “Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль”-д санал өгөх

25. Нохойтой айл өрхийн судалгааг багийн захиргаа, хотын захирагчийн алба, ТҮГ-тай хамтран иж бүрэн хийж авах. Үүний дагуу нохойны хураамж төлөх үүргийг цахим мэдээллийн санд бүртгэх, хураамж төлсөн эсэхээс шалтгаалан төрийн үйлчилгээг авах эрхийг нээх /тодорхойлолт авах г.м/ хөшүүргийн механизмыг бий болгох, мэдээллийн санд тухай бүр өөрчлөлтийг хийж ажиллах талаар холбогдох байгууллагуудад үүрэг чиглэл өгөх
26. Аймаг, орон нутагт орох орлогыг нэр төрлөөр нь бодит тоо үзүүлэлтэд тулгуурлан нөөц боломжийг бүрэн дайчлан оруулахаар төлөвлөлтийг хийж ажиллах
27. Оны эхэнд аймгийн хэмжээнд бүртгэлтэй тээврийн хэрэгслийн төлөх татвар, замын сангийн хураамж зэрэг ногдлууд програмд бүрэн гүйцэд орсон эсэхийг нягтлан шалгаж байх талаар Татварын хэлтэст үүрэг чиглэл өгөх
28. АТӨЯХАТатвар, замын сангийн хураамж, газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөг нөөц бололцоонд тулгуурлан төлөвлөлтийг хийх, өр авлага үүсгэхгүй байхад анхаарч ажиллах
29. Газрын алба нь газрын төлбөрийн ногдуулалтыг газар эзэмшигч нэг бүрээр тулган шалгаж, алдаа зөрчлийг арилган, ногдуулалтыг үнэн зөв хийгдэх боломжийг бүрдүүлэх